ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ

**АУДИТЫН КОД: САГ-2020/122/СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.


**Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг**
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
**Аудитын менежер Г.Гүнжидмаа**
Утас: 260512 Цахим хаяг: gumjidmaag@audit.gov.mn
**Аудитор Ц.Цэрэнхүү**
Утас: 261885 Цахим хаяг: tserenkhuuts@audit.gov.mn
**Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Баян ташаагийн эх аудит" ХХК**
Утас:99116028 Цахим хаяг: bte.audit@yahoo.com



Улаанбаатар хот
2020 он

# ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Агуулга

1.Аудитын гэрчилгээ ..... 2
2.Аудитын тайлан ..... 4
2.1. Оршил ..... 4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ..... 4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ..... 4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ..... 5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... 5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ..... 5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ..... 6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ..... 6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..... 6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ..... 7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..... 7
2.12. Шилэн дансны мэдээлэл ..... 7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт ..... 7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ..... 8
3.Менежментийн захидал ..... 9
4.Аудит хийсэн санхүүгийн тайлан ..... 10
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 10
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 11
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 13
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 15
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 16
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ..... 18
4.7 Аудит хийсэн төсвийн тохируулгын тайлан ..... 19
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ..... 20

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.02.27 № 06/629

танай ____________ -ны № ____________ -т

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ Н.ЦОГБАДРАХ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

9000109
9019120596

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2020\0227SAG19.Docx

## 2.Аудитын тайлан

### 2.1. Оршил

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захирал Н.Цогбадрах танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагналын системийг боловсронгуй болгох Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэхтэй холбоотой зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 31-нээс 2020 оны 02 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Баян ташаагийн эх Аудит” ХХК-ийн аудитор Т.Хоролсүрэн, Л.Наранцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Зоонозын өвчин судлалын үндэсний төв 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 1/90 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь зоонозын халдварт өвчнийг тандах, хянах, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг судалгаа, нотолгоонд тулгуурлан мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж, халдварын эрсдэлийг багасгах замаар хүн амын өвчлөл эндэгдлийг бууруулахад оршино.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Зоонозын халдварт өвчний тандалт судалгаа, эрдэм шинжилгээ, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг зохион байгуулах, хүн амыг халдвараас хамгаалах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэх, журам батлах тухай ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоол
- Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2019 оны 268 дугаар тогтоол
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоол Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээ
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 25 дугаар тогтоол Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоол Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох
- Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/548 тоот тушаалаар Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдын хоол, унааны хөнгөлөлт нэмэгдэл, урамшлын хэмжээг тогтоох тухай

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Зоонозын өвчин судлалын үндэсний төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ийн Acolous программ хангамж ашиглаж байна.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 10 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгосон дүн 3,780,684.7 мянган төгрөгөөс тооцон 37,806.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшин өөрчлөгдөөгүй байна.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 603,095.4 мянган төгрөгөөр буюу 15.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Урьдчилгаа | | | - |
| Бараа материал | 671,542.1 | 870,454.9 | 198,912.8 |
| Үндсэн хөрөнгө | 3,162,198.0 | 3,566,380.6 | 404,182.6 |
| **Нийт хөрөнгө** | 3,833,740.1 | 4,436,835.5 | 603,095.4 |
| Өр төлбөр | | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 3,833,740.1 | 4,436,835.5 | 603,095.4 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 3,833,740.1 | 4,436,835.5 | 603,095.4 |

Бараа материалын дансны үлдэгдэл 198,912.8 мянган төгрөгөөр өссөн. Энэ нь гэнэтийн болон олныг хамарсан цаг үеийн бэлэн байдлын нөөц бэлтгэхтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 3/1330 тоот шийдвэрийг үндэслэн 20,205.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 4,400.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил мөн зөвшөөрөлгүйгээр 10,000.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил нийт 36,605.5 мянган төгрөгийн хөрөнгийг худалдаж авсан. Мөн дээд шатны байгууллагаас 607,105.3 мянган төгрөгийн газель автомашин, 31,500.0 мянган төгрөгийн фургон автомашин, нийт 701,605.3 мянган төгрөгийн хөрөнгийг авто тээврийн хэрэгсэл дансанд үнэ төлбөргүйгээр хүлээн авч бүртгэсэн. Р 53 төслийн хандив тусламжаар 13,814.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, Испани улсын Порбитас сангийн санхүүжилтээр 23,026.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 5,670.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, нийт 42,510.7 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар хүлээн авсан.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Зооноз өвчин судлалын үндэсний төв нь тайлант онд 6,631.7 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөө батлагдсанаас гүйцэтгэлээр 10,303.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж төлөвлөгөөг 155.4 хувиар биелүүлсэн байна.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх нийгмийн эрүүл мэнд хөтөлбөрт зориулан 2,252,789.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан, үүнээс 2,218,183.5 мянган төгрөгийг урсгал зардалд, 34,605.5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар хуваарилсан байна.

Нийт зардлын 2,246,157.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 6,631.7 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

**Нэмэлт төсөв:** Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж 164,858.6 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан хөрөнгө 75,169.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 14,485.8 мянган төгрөг, нийт 254,513.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж ажилласан байна.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 12,202.6 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 1,647.4 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 5,546.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 24,767.9 мянган төгрөг, норматив зардалд 84,607.1 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 37,601.0 мянган төгрөг, томилолт зочны зардалд 25,707.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 23,543.5 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээний бусад зардалд 2,464.0 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэгт 36,426.9 мянган төгрөг, нийт 254,513.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

**2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 10 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 11 эрсдэл тодорхойлж горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 23,085.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 13,085.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 10,000.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Үүнд:

1 Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захирлын 2019 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн Б/152 тоот тушаалыг үндэслэн 76 ажилтанд 13,085.2 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг бүх ажилтанд 25 хувиар олгосон нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3-д “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно” гэсэнтэй нийцэхгүй, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

**2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

**2.12. Шилэн дансны мэдээлэл**

Зоонозын өвчин судлалын үндэсний төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 144 удаагийн мэдээллийг хуулийн хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

**2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5,332.3 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгснөөс зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

**2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 23,085.2 мянган төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон 37,806.8 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

"Зөрчилгүй" дүгнэлт

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3.Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмж цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *Балансын данстай холбоотой асуудал*

*1.1. Илрүүлэлт:*

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэргүйгээр 10,000.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдаж авсан.

Энэ нь "эрх ба үүрэг" батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэх, журмын 4.2-д "Төсөвт хуулийн этгээд нь Төсвийн тухай хуулийн батлагдсан урсгал төсөв, нэмэлт төсөв, хэмнэсэн төсөв болон давсан орлогоос үндсэн хөрөнгө бэлтгэх бол хэрэгцээ, шаардлагаа тодорхойлж, зайлшгүй хэрэгцээтэй хөрөнгийн жагсаалт, тоо хэмжээ, худалдан авах үнийн дээд хязгаарын саналыг дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагч дэмжсэн тохиолдолд Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зөвшөөрөл олгоно" гэж заасныг зөрчсөн байна.

*1.2. Эрсдэл:*

Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах.

*1.3. Өгсөн зөвлөмж:*

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэх, журмыг мөрдөж ажиллах.

*1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **671,542,079.73** | **870,454,935.22** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | - | - |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | - |
| **33** | **АВЛАГА** | - | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 671,542,079.73 | 870,454,935.22 |
| **351** | **Түүхий эд материал** | 562,865,231.66 | 760,612,222.15 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 310,838,604.50 | 307,540,404.50 |
| 35130 | Эм боох материал | 252,026,627.16 | 453,071,817.65 |
| **354** | **Хангамжийн материал** | 108,676,848.07 | 109,842,713.07 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 6,420,596.00 | 3,715,718.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 59,556,757.12 | 71,284,607.12 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 5,248,000.00 | 5,692,560.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 16,512,972.19 | 7,249,068.19 |
| 35450 | Барилгын засварын материал | 12,765,075.00 | 12,490,675.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 8,173,447.76 | 9,410,084.76 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,162,198,033.91** | **3,566,380,587.22** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,162,198,033.91 | 3,566,380,587.22 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,404,968,079.59 | 2,813,699,274.66 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,895,666,168.00 | 1,895,666,168.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (6,155,079.80) | (136,839,673.16) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 290,370,094.00 | 991,975,414.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (244,805,268.85) | (292,937,440.57) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 1,988,516,780.84 | 2,063,663,005.07 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (1,608,632,005.86) | (1,801,323,459.27) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 249,675,496.88 | 269,745,496.88 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (159,668,105.62) | (176,250,236.29) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 446,551.76 | 446,551.76 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (446,551.76) | (446,551.76) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 757,229,954.32 | 752,681,312.56 |
| 39301 | Програм хангамж | 25,880,567.10 | 25,880,567.10 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (18,375,362.78) | (22,924,004.54) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 749,724,750.00 | 749,724,750.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,833,740,113.64** | **4,436,835,522.44** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,833,740,113.64** | **4,436,835,522.44** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,833,740,113.64 | 4,436,835,522.44 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,698,660,655.49 | 2,698,660,655.49 |
| 51101 | Өмч: - төрийн | 2,698,660,655.49 | 2,698,660,655.49 |
| 51102 | - хувийн | | |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (170,138,872.15) | 432,956,536.65 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (170,138,872.15) | (170,138,872.15) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 603,095,408.80 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,305,218,330.30 | 1,305,218,330.30 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,833,740,113.64** | **4,436,835,522.44** |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,060,540,862.39** | **4,383,780,180.13** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **79,190,962.39** | **1,883,108,950.13** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 79,190,962.39 | 1,883,108,950.13 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 79,190,962.39 | 1,883,108,950.13 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,045,640.00 | 10,303,037.90 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 75,145,322.39 | 1,872,805,912.23 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,981,349,900.00** | **2,500,671,230.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,814,364,000.00 | 2,246,157,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,814,364,000.00 | 2,246,157,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 166,985,900.00 | 254,513,930.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 164,858,560.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 166,985,900.00 | 75,169,500.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 14,485,870.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,413,271,168.47** | **2,756,558,213.33** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,413,271,168.47** | **2,756,558,213.33** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,307,946,893.36 | 2,576,189,673.50 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,110,383,452.87 | 1,313,940,367.26 |
| 210101 | Үндсэн цалин | 709,299,800.00 | 801,480,358.80 |
| 210102 | Нэмэгдэл | 241,038,262.87 | 311,239,008.46 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 76,774,500.00 | 118,965,600.00 |
| 210104 | Урамшуулал | 83,270,890.00 | 82,255,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 140,753,884.22 | 182,642,845.90 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 100,345,778.41 | 117,399,450.47 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,643,500.00 | 10,639,117.14 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,860,021.59 | 26,006,284.16 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,028,500.00 | 2,752,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,876,084.22 | 25,845,894.13 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 73,121,216.80 | 74,304,810.98 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 35,118,898.40 | 35,548,826.00 |
| 210302 | Түлш, халаалт | 28,639,070.00 | 28,385,325.01 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,433,248.40 | 4,824,659.97 |
| 210304 | Байрны түрээс | 4,930,000.00 | 5,546,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 90,479,251.07 | 92,685,115.93 |
| 210401 | Бичиг хэрэг | 14,316,213.00 | 15,092,958.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 52,456,417.33 | 62,093,130.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,676,800.18 | 4,848,114.93 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 10,087,353.94 | 10,650,913.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 8,942,466.62 | |
| **2105** | **Нормативт зардал** | 378,353,519.83 | 416,450,609.51 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 356,577,669.83 | 396,505,559.51 |
| 210502 | Хоол, хүнс | 21,734,000.00 | 19,813,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 41,850.00 | 131,650.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,341,515.00 | 18,704,390.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 697,500.00 | 1,333,185.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,644,015.00 | 17,371,205.00 |
